

ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ

С.ЭРДЭНЭБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ГАДНА ХАШАА ХИЙХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймгийн Хатанбулаг сум Эрүүл мэндийн төвийн гадна хамгаалалтын төмөр сараалжин хашааны ажил: Хашаны нийт урт нь 330.15м хэмжээтэй, бетон шугаман суурьтай, 2 авто хаалгатай, 2 явган хаалгатай /.

А. Ажил гүйцэтгэх хугацааны график/ хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсрууж ирүүлнэ.

Б. Хашааны угсралтын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх.

В. Үнийн саналд зураг төсвийн үнэ **2048400** төгрөгөөр, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тус тус тусгаж ирүүлнэ..

1. Газар шороо, суурийн ажил

- Хашааны газар шороо суурийн ажлыг гүйцэтгэхэд БНБД 3.02.01-90-г баримтална.

- Суурийг механизмаар ухахдаа 20-30 см –ийн зузаантай үлдээж гараар ухаж өгнө.

- Хашаа нь бетон шугаман суурьтай, байхаар төлөвлөсөн бөгөөд 100 мм зузаан бетон үетэй. бетоны марк В15 байна.

- Суурийн ажлыг цутгалтын аргаар гүйцэтгэхэд хэв хашмалыг MNS3173:2002 стандарт, хэвэнд хэрэглэгдэх мод төмөр, хуванцар ба бусад төрлийн дагалдах тоноглол нь MNS0914:86, MNS4237:94, MNS2630:89, MNS2332:89, MNS3219:82-ийн шаардлагыг хангасан байх бөгөөд бетоны бэхжилтийн 70%-г авсаны дараа хэв хашмалыг суллана. Цутгалтанд хэрэглэх хайрга, дайрга MNS0390:1998, бетон зуурмаг нь MNS1185:1985 техникийн шаардлагыг хангасан байна.

Мөн цутгалтанд тоосжилтгүй стандартын шаардлагад тохирсон элс хэрэглэнэ.

Цутгалтын ажил гүйцэтгэхэд БНБД3.03.02-90-г баримтална. Халууны улиралд бетон хийхдээ бетоныг хэт хатахаас хамгаалж өгөх шаардлагатай. Сууринд хэвтээ болон хажуугийн ус тусгаарлагчийг зурагт заасны дагуу хийж өгнө.

Цутгамал бетон бүтээц БНБД 3.03.01-88-г баримтална. Бетон цутгалтыг дулааны улиралд хийж гүйцэтгэх ба хуурай халуун нөхцөлд бетонд арчилгаа хийх шаардлагатай.

Хашааны суурийг гадна дотор талаас нь шохойн будгаар будна .

Хашаан нь 60х60х3 мм тэгш өнцөгт хөндий төмөр шонтой, дээр доороо 50х30х2 мм хэмжээтэй тэгш өнцөгт төмөр бэхэлгээтэй, 20х20х2 мм хэмжээтэй тэгш өнцөгт төмөр төмөр босоо сараалжтай зураг төсөлд заасны дагуу угсарна.

Авто болон явган хаалгыг зураг төсөлд зааны дагуу хийж гүйцэтгэнэ. Хайс хашааг өнгийн төмрийн будгаар 2 удаа будна. Хашааны төмөр хийцийн зузааныг зураг төсөлд заасан хэмжээнээс багаар хийхийг зөвшөөрөхгүй.

Хашааны гагнуурыг хийхдээ стандарт норм дүрмийг баримтлан хийх бөгөөд гагнуурын өө сэвийг сайтар цэвэрлэсний дараа будаг хийнэ.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь: Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлыг гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторын шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ лабораторын шинжилгээний дүн, падаан хавсаргана.

-Барилга угсралтын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.

-Барилгын тухай хууль /шинэчилсэн найруулга/ -ийн 14.3 заасны дагуу ашиглалтанд өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хий, бүтээц, цэвэр бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

-Гүйцэтгэсэн ажлыг ил далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

-Хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.

-Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлага зэргийг биелүүлнэ.

-Дээрх техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, зураг төслийн байгууллагын төлөөлөгч эрхийнхээ дагуу угсралтын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

-Үнийн саналын тооцоог батлагдсан төсвийн праграммаар хийж Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "IY" 81-95-12-г мөрдлөг болгоно.